

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХЯМРАЛ БА МОНГОЛ УЛС

Д. Намсрай¹

АНУ-д анх үл хөдлөх хөрөнгө, санхүүгийн зах зээлд үүссэн хямрал нь нийгэм эдийн засгийн бусад салбарыг төдийгүй дэлхийн бусад улс орныг богино хугацаанд хамран дэлхийн эдийн засгийн ээлжит хямрал болж байна. Хэдийгээр Хятад, Япон зэрэг зарим улс орнуудын хувьд эдийн засаг нь сэргэх хандлага ажиглагдаж байна гэж үзэж байгаа ч бүхэлдээ дэлхийн эдийн засгийн сэргэлт маш удаан явцтай байна. Үүний хамт ажилгүйдэл, ядуурал, ханш уналт зэрэг эдийн засгийн хүндрэлтэй асуудлууд байсаар байна. Саяхан Евро бүсийн орнуудын Сангийн болон Эдийн засгийн сайд нарын хурлаас өөрийн валютын ханшийг сулруулах арга хэмжээг авахаа мэдэгдэв. Гол шалтгаан нь еврогийн ханш чангарсаар байгаа нь Европын холбооны улсуудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварт муугаар нөлөөлснөөс экспортын хэмжээ багасч байна гэж үзжээ.

Дэлхийн эдийн засгийн 1930, 1970-аад оны хямрал, 1990-ээд оны Азийн зарим орныг хамарсан хямралууд нь үүссэн шалтгаан, үргэлжлэх хугацаа, хамрах хүрээ далайцаараа өөр өөрийн онцлогтой юм. Үүний нэгэн адил энэ удаагийн хямрал ч өөрийн онцлогтой байна. Швейцарийн Давос хотноо Дэлхийн эдийн засгийн чуулган болж, олон орны төр засгийн тэргүүнүүд оролцон энэ удаагийн хямралаас аль болох богино хугацаанд хохирол багатай гарах арга замаа хэлэлцэв. Чуулганы төлөөлөгчид дэлхийн тэргүүлэх төв банкуудад хандан хямралтай хамтран тэмцэхийг уриалсан байна. Энэ удаагийн хямрал нь хамгийн богино хугацаанд дэлхийн улс орнуудыг өргөн далайцтай хамарснаараа 1940-өөд оноос хойш болж байгаагүй хямрал гэж дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын төлөөлөгчид дүгнэжээ.

Эдийн засгийн уналт хямрал бол хөгжлийн салшгүй бүрэлдүүн хэсэг юм. Хөгжлийн цикл нь өөрөө өсөлт өрнөлтөөр дамжин оргил үедээ хүрч, буцаж уруудсаар уналтын доод цэгтээ хүрч эргээд өсч эхэлдэг онолын үндэстэй бөгөөд энэ нь түүхийн үеүүдэд нотлогдсон ажээ. Хямрал нь хөгжлийн шинэ эрин үеийн эхлэл бөгөөд шинэ нөхцөлд зохицох дохио юм. Энэ удаагийн хямрал нь өргөн цар хүрээг хамарч, дэлхийн улс орны нийтлэг эрх ашгийг хөндөж байгаа нь олон улсын харилцаа, хамтын ажиллагааны шинэ үе шат эхэлж, улс гүрнүүд бие биенээсээ үл хамааран оршин тогтнох нь хүндрэлтэй болох глобалчлалын эрин үеийн дохио гэж болох юм. Даяаршсан хямрал нь олон улсын эдийн засгийн гол судас нь болсон гадаад худалдаа, ялангуяа экспортын хэмжээг эрс бууруулснаар өсөлтийг сааруулж байна.

Эрдэмтэн судлаачид, ялангуяа АНУ-ын эрдэмтдийн зүгээс энэ хямрал нь аль хир удаан үргэлжилж уналтын цэгтээ хэзээ хүрэх талаар олон санаа бодол дэвшүүлж байв. Улс орнууд хямралаас гарах өөрсдийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Хямралаас гарах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд улс бүхэнд их хэмжээний мөнгө хэрэгтэй байсан. Хөрөнгийн эх үүсвэрийг улс орнууд янз бүрийн арга замаар хангаж байна. Хөгжсөн орнуудын тухайд бол Засгийн газраас бонд гаргаж иргэдийнхээ хадгалсан мөнгийг татах, улсын нөөц сангаа ашиглах гээд голдуу өөрийн дотоод боломжоо дайчлан шийдвэрлэж байна. Эдийн засгаа аврах хөрөнгийн эх үүсвэрийг АНУ, Герман, Англи, Шинэ Зеланди, Япон гэх мэт өндөр хөгжсөн орнууд засгийн газрын богино болон урт хугацаатай бондын орлогоор бүрдүүлж байна. Тухайлбал Япон улс хямралыг даван туулахын тулд 200 гаруй тэрбум доллар шаардлагатай гэж үзсэн. Тэгвэл японы иргэдийн хувийн хадгаламжийн хэмжээ 15.2 триллион доллар байгаа

¹ МУИС, ОУХС-ийн багш, Ph.D

бөгөөд эдийн засгаа аврахын тулд иргэдийнхээ энэ мөнгийг ашиглахаар Засгийн газрын бонд гаргасан байна. Тэгвэл манай хөрш Хятад улс хэдийгээр хөгжиж байгаа орны тоонд ордог ч хүчтэй эдийн засагтай орон билээ. Хятад улсын төсөв нь ашигтайгаас гадна ашигт малтмалын дэлхийн зах зээлийн үнэ өндөр байхад “хуримтлуулах бодлого” баримталсан нь одоо үр өгөөжөө өгч 3-4 жилд төсөв алдагдалтай гарсан ч нөхөж чадах хуримтлалтай болсноороо хямралыг даван туулах хөрөнгө хангалттай байна. Түүнээс гадна Хятадын засгийн газар нь хямралын эсрэг авах арга хэмжээг хугацаа алдалгүй 2008 оноос эрчимтэй хэрэгжүүлж эхэлсэн байна.

Зарим судлаачдын үзэж байгаагаар хөгжиж байгаа зарим орны хувьд эдийн засгийн хямрал нь илүү удаан үргэлжилж болзошгүй ажээ. Энэ нь тэдгээр орны эдийн засгийн чадавхи дорой, хямралыг даван туулах санхүү, хөрөнгийн эх үүсвэргүй байгаатай холбоотой. Хөгжиж байгаа орнууд ялангуяа ядуу орнуудын хувьд хямралыг даван туулахад шаардлагатай байгаа хөрөнгийн эх үүсвэрээ хүн амаасаа юмуу эсвэл хуримтлалын сангаасаа хангах боломж байхгүй бөгөөд тэд олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл тусламжид найдаж байдаг.

Манай улсын санхүү эдийн засгийн хямралыг даван туулах төлөвлөгөөг 2009 оны 3-р сард УИХ-аар батлав. Энэхүү төлөвлөгөөгөөр хямралаас гарахад 2.365,0 тэрбум төгрөг² (1) шаардлагатай байсан бөгөөд энэ мөнгийг олоход тухайн үедээ нилээд хүндрэлтэй тулгарч байсан ч ОУВС, ДБ, АХБ, Япон улс зэрэг олон улсын байгууллага, хандивлагч орнууд манай улсад тодорхой хэмжээний хөнгөлөлттэй зээл олгосон юм.

Манай улсын эдийн засаг нь дэлхийн эдийн засгийн хямралаас шууд хамааран өөрчлөгдөж байгааг өнгөрсөн богино хугацаанд нийгэм эдийн засагт гарсан өөрчлөлт харуулж байна.

Манай улсад 2008 оны эцэс, 2009 оны эхнээс эхлэн дэлхийн эдийн засгийн хямрал нөлөөлж байгаа нь илт мэдрэгдэж эхэлсэн. Тухайлбал улсын нэгдсэн төсөв 2007, 2008 оны эхний улирлын байдлаар алдагдалгүй гарч байсан бол 2009 оны эхний улиралд 106,9 тэрбум төгрөгийн алдагдалтай болов. Үүнд татварын орлого 138,1 тэрбум төгрөгөөр дутсан буюу тодорхой хэлбэл зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар, аж ахуйн нэгжийн албан татвар, нэмүү өртгийн татвар буурсан явдал нөлөөлсөн. Гол шалтгаан нь манай улсын гадаад худалдаа нийт дүнгээрээ 2009 оны эхний улиралд өнгөрсөн оны мөн үеийнхээс 39,3 %-иар буурч, гадаад худалдааны тэнцэл алдагдалтай гарсан байна. Гадаад худалдааны нийт эргэлт буурахад импорт, экспорт хоёулаа буурсан нь нөлөөлсөн. Экспортын хэмжээнд алт, зэс, цайр зэрэг бүтээгдэхүүний худалдаа 50 орчим хувь буурсан нь нөлөөлсөн бол импортын хэмжээнд валютын ханш өссөн, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн худалдан авах чадвар буурсан, бүтээгдэхүүний борлуулалт удааширсан зэрэг шалтгаанууд нөлөөлсөн байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо зөвхөн 2009 оны эхний ганцхан улиралд 16,4%-иар өссөн. Албан бүртгэлд хамрагдсан ажилгүйчүүдийн тоогоор тооцсон ажилгүйдлийн түвшин 4% байсан ч бүртгэлгүй ажилгүйчүүдээр тооцвол манай улсын ажилгүйдлийн түвшин 20% элбэг хүрдэг гэсэн судлаачдын тооцоо, дүгнэлт олон байдаг. Хэдийгээр энэ нь нэлээд эртнээс улбаатай ч хүн амын ядуурал 30 гаруй хувь болчихоод байгаа нь ажилгүйдэл хирээс хэтэрснийг нотолж байгаа юм. Гадаад валютын ханш тухайлбал америк долларын хувьд 1170₮-өөс 1770₮ болж өссөн. Валютын ханш огцом өссөнөөр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсч, инфляцийн түвшинг 34.2 хүртэл хөөрөгдөв. Ингэж хүн амын амьжиргааны өртөг өндөр болсон нь худалдан авах чадварыг бууруулсан. Ганцхан жишээ хэлэхэд Засгийн газраас баталдаг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг (ХХДХ)-ээр тооцсон нэг сарын цалин 108000 ₮ нь дээрх ханшны өөрчлөлтөөс хамаарч 2007 оны эхээр 92 \$ -той тэнцэж байсан бол ханш 1770 болох үед 61\$ болтлоо унасан юм. Эдгээр тоо баримтуудаас дүгнэвэл дэлхийн санхүү эдийн засгийн хямрал манай улсын эдийн засагт богино хугацаанд шууд нөлөөлсөн. Энэ нь манай улсын эдийн засгийн гол судас нь болоод байгаа дэлхийн зах зээлд экспортолдог цөөн нэрийн бүтээгдэхүүний үнэ буурсантай холбоотой. Өөрөөр хэлбэл үндэсний эдийн засаг цөөн нэрийн бүтээгдэхүүний экспортоос хараат, ядуу бүтэцтэй байгаатай холбоотой.

² Өдрийн сонин № 053, 2009.03.04

Үндэсний статистикийн хорооноос 2009 оны эхний 9 сарын байдлаар манай нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг судалжээ. Түүнээс дүгнэвэл манай улсын нийгэм эдийн засгийн нөхцөл байдал өнгөрсөн оны мөн үеийн түвшингөөс эрс буурсан байна. Улсын төсвийн алдагдал 2009 оны эхний 9 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 329 тэрбум төгрөгөөр өссөн байна. Татварын нийт орлого өнгөрсөн оноос 24.3 хувь буурсны дотор зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар 73.0 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 35.4 тус тус буурчээ. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл өмнөх оноос 10.5 хувиар хумигдаж, ажилгүйчүүдийн тоо 27.1 хувиар нэмэгдсэн байна. Зарим улс орны эдийн засаг сэргэж эхэлснийг сар сарын мэдээг харьцуулан гаргаснаар тайлбарлаж байна. Манай улсын хувьд 2008 оны мөн үетэй харьцуулан гаргасан албан мэдээлэл дээр үндэслэн хэлбэл эдийн засагт сэргэлт ажиглагдахгүй байгаа бөгөөд уналт үргэлжилсээр байгаа бололтой.

Манай улсын эдийн засгийн бүтэц бие даах чадвар муу, улсын төсөв нь цөөн нэрийн экспортын бүтээгдэхүүнээс хараат, хүнсний хэрэглээ нь импортоос хамааралтай, ажилгүйдэл өндөр учраас хүн амын ядуурал их, үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар муу байна. Товчхон хэлбэл үндэсний эдийн засаг ядуу бүтэцтэй байна. Түүний зэрэгцээ төрөөс авч байгаа бодлогын арга хэмжээнд ч алдаа гарч байна. Дэлхийн зах зээл дээр алт, зэсийн үнэ өндөр байсан үед улсын төсөвт их хэмжээний мөнгө орж байсан боловч сонгуулийн амлалтаас болж ард түмэнд бэлнээр нь тараах, халамжийн тэтгэлгийг хавтгайруулснаас хямралын үед зарцуулах хуримтлал ч үгүй байна. Атрын 3-р аяны үр дүнд төмс хүнсний ногоо, үр тарианы үйлдвэрлэлд ахиц гарсан хэдий ч түүнийгээ нөөцлөх эрүүл ахуйн шаардлага хангасан зоорины асуудлаа шийдээгүй болохоор ирэх жилийн ургац хүртэл хэрэглэж, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих боломжгүй бололтой. Оюу толгойн орд газрыг ашиглах гэрээнд гарын үсэг зурснаар анхны зээлийн мөнгө 100 сая ам. доллар орж ирсэн боловч түүнийгээ ядуу ард түмэндээ тавин мянгаар нь тараагаад дуусах юм байна. Уг нь бол бид хэдийгээр ядуу боловч тавин мянгаар амьдралаа сайжруулж чадахгүй. Харин 100 сая ам. долларыг үр ашигтай зарцуулбал бага мөнгө биш. Аливаа асуудлыг шийдэхдээ ард иргэд, олон нийтийн санал авдаг ардчилсан зарчим хэрэгжихгүй байна. Ардчилсан зарчим бол ганц сонгууль биш юм. Гадаадын зээл тусламжийн мөнгийг үр ашигтай зарцуулахад хяналтын тогтолцоо байхгүй байна.

Эдийн засгийн ядуу бүтцийг яаж гэтлэн давах вэ? гэдэг нь зөвхөн хямралын асуудал биш. Энэ нь манай улсын эдийн засгийн хөгжлийн асуудал юм. Хөгжиж байгаа ядуу орны хувьд ганц тодорхой байгаа боломж бол байгалийн баялгаа ашиглах явдал байдаг. Уул уурхайн олборлох боловсруулах үйлдвэрийг гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран ашигласнаар манай улсад их хэмжээний орлого олох боломж нээгдэж байна. Энэ нь экспортын хэмжээг нэмэгдүүлээд зогсохгүй, хөдөө орон нутагт хөгжлийн төвүүд үүсч хүн амын төвлөрлийг бий болгох, хөгжих боломж өгнө. Уул уурхайн салбар нь шинэ техник технологи нэвтрүүлж, орчин үеийн мэрэгшсэн ажиллах хүчийг бий болгоод зогсохгүй түүнд үйлчлэх үйлдвэрлэл, үйлчилгээний бусад олон салбарыг хөгжүүлэх эрэлт хэрэгцээ, зах зээлийг бий болгоно. Айвенхоу Майнз, Оюу Толгойн уурхайн захиргаанаас ийм үйл ажиллагаа явуулах хүсэлтэй компаниудын саналыг аваад эхэлсэн байна. Гэвч мэргэжлийн зарим хүмүүсийн үзэж байгаагаар энэ тендерт Монголын үндэсний компаниуд шалгарахад өрсөлдөх чадварын хувьд учир дутагдалтай ажээ. Энэ учраас энэ салбаруудад үйл ажиллагаа явуулах хүсэлтэй үндэсний жижиг дунд үйлдвэрүүдэд төрийн зүгээс бодлогын хүрээнд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Уул уурхайн салбарыг хөгжүүлснээр олох ашгаараа олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай бусад салбаруудыг хөгжүүлж эхлэх нь бодлогын түвшинд зохицуулах асуудал мөн. Боловсрол, эрүүл мэнд, оюуны багтаамжтай салбарууд, ер нь үйлчилгээний салбаруудыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх нь зүйтэй.

Уул уурхайн салбарыг хөгжүүлэх нь байгаль орчин, аюулгүй байдлын талаас ихээхэн анхааралтай байхыг шаарддаг нь хөгжиж байгаа орнуудын туршлагаас нэгэнт тодорхой болжээ. Байгаль орчныг нөхөн сэргээх нь өвс ургамал, ой бий болгосноор хэрэгждэггүй. Харин агаар, ус, хөрсний бохирдлыг арилгаснаар шийдвэрлэгддэг учраас түүнд зориулагдсан орчин үеийн

нарийн тоног төхөөрөмжөөр мэргэжлийн байгууллагуудыг хангах ёстой юм.

Ажилгүйдэл ядуурлыг жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийг хөгжүүлснээр шийдвэрлэдэг олон улсын туршлага байна. Уул уурхайн олборлох боловсруулах үйлдвэрийг хөгжүүлснээр Эрдэнэт, Дархантай ижил хүн ам төвлөрсөн хөгжлийн төвүүдийг бий болгож, түүний ойр орчмын бүс нутагт хот сууринд үйлчилдэг орчин үеийн эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, хүнсний болон бусад олон салбарын ЖДҮ-үүдийг цогцоор нь хөгжүүлэх боломжтой бөгөөд дээр хэлсэнчлэн Монгол улсад эрх авсан гадаадын аж ахуйн нэгжүүдтэй үндэсний ЖДҮ-үүд өрсөлдөх чадвар муу байгааг анхаарч төрөөс бодлогоор дэмжих хэрэгтэй байна.

Манай улсад ЖДҮ хөгжүүлэх нэн шаардлагатай салбар бол хөдөө аж ахуй хүнсний салбар мөн. 1990-ээд оноос өмнө манай улс хүнсний үндсэн нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж чаддаг байсан бол одоо ихэнхийг нь Хятад болон ОХУ, Европын орнуудаас импортоор авч байна. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт үндэсний ЖДҮ-ийг хөгжүүлэх нь хүнсний аюулгүй байдлын үүднээс ч нэн чухал байна. ЖДҮ-ийг хөгжүүлэх боломжтой өөр нэг салбар нь барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбар юм. Манай улс барилгын материалын түүхий эдийн нөөцөөр баялаг. Үүнийгээ түшиглээд ЖДҮ хөгжүүлбэл импортоор аваад байх шаардлагагүй. Орон сууц барилгын хэрэгцээ их байгаа. Асар олон хүн орон сууцанд орохыг хүсч байна. ЖДҮ хөгжүүлэх боломжтой бас нэг салбар бол замын салбар мөн. Монгол улс өргөн уудам нутагтай замын асуудал маш чухал. Засгийн газар энэ дөрвөн жилд нийслэл УБ хотыг бүх аймгийн төвтэй хатуу хучилттай замаар холбохоор төлөвлөсөн. Энэ ажлыг хийхээр замын салбарт олон ЖДҮ-үүд бий болчихоод байгаа. ЖДҮ нь том үйлдвэрүүдтэй харьцуулахад олон давуу тал байдгийн нэг нь зах зээлийн эрэлт хэрэгцээг хурдан мэдэрч, зохицох чадвартай байдаг. Харин хамгийн гол дутагдал нь санхүү хөрөнгийн хувьд жижиг учраас төрөөс байнгын дэмжлэг зохицуулалт шаарддаг. ЖДҮ-үүд нь төрөөс институци, хууль эрх зүйн бүхэл бүтэн тогтолцоогоор дэмжиж байж хөгждөг. Өнөөдөр Оюу Толгойн уурхайд туслах үйлчлэх олон салбарын бизнесийг эрхлэх компаниудыг тендерт урих гэж байгаа явдал нь үндэсний үйлдвэрүүдээ төрөөс бодлогоор дэмжихийг зайлшгүй шаардаж байна. Уул уурхайн салбарыг хөгжүүлж улс орны орлогыг нэмэгдүүлэх, олсон орлогоо оюуны чадамжтай өөр салбаруудыг хөгжүүлэхэд үр ашигтай зарцуулах, хуримтлалтай болох, уул уурхайн үйлдвэрүүд бий болсноор үүсэх хөгжлийн төвүүдийг тойрсон ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих талаар төрөөс бодлогын түвшинд анхаарах нь чухал боллоо.